

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу шалгаж үзвэл:

1.Иргэнд үүсэх зардлыг цаг хугацааны болон шууд бий болох мөнгөн зардал гэсэн үзүүлэлтээр нэг жилд бий болох зардлыг тооцож гаргадаг бөгөөд хуулийн төсөлд иргэнд ямар нэг үүрэг болгосон заалт байхгүй тул түүнд зарцуулах хугацаа, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсэхгүй болно.

2.Хуулийн этгээдэд нэг жилд бий болох хүний нөөцийн болон мөнгөн зардлыг тооцдог бөгөөд тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалт байхгүй тул хүний нөөц шинээр бий болох, түүнтэй холбоотой мөнгөн зардал үүсэхээргүй байна.

Харин энэ хэсэгт мэдээлэл болгох үүднээс компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулдаг мөнгөн дүнгийн талаарх зарим мэдээлэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийн хэрэгжилтийн талаарх зарим мэдээллийг харуулбал:

ДНБ-ий 70 гаруй хувийг бий болгодог хувийн хэвшлийнхэн орлогынхоо тодорхой хэсгийг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд зарцуулдаг байна. МҮХААТ-аас явуулсан судалгаагаар 256/судалгаанд оролцсон/ аж ахуйн нэгжийн 8.3 хувь нь 0-10, 33.4 хувь нь 10-50, 10.5 хувь нь 50-100, 16.9 хувь нь 100-500 сая төгрөг, 11.0 хувь нь 500 саяас нэг тэрбум төгрөг, 20 хувь нь нэг тэрбумаас дээш төгрөг зарцуулдаг байна.

2023 онд 3,865 ААН, нийт 68,567.39 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгжийн тоо 78 буюу 2 хувиар, хөнгөлөлтийн дүн 9,192.89 сая төгрөг буюу 15.5 хувиар өссөн байна. Түүнчлэн, 2023 онд хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгчийн тоо 2020 оноос 92 хувиар, хөнгөлөлтийн дүн мөн оноос 97 хувиар тус тус өссөн байна.¹

3.Төрийн байгууллагад хүний нөөц шинээр болох, шинэ бүтэц бий болохтой холбоотой зардлыг нэг жилээр тооцож гаргах бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаас харахад ийм төрлийн зардал бий болохооргүй байна.

¹ ААНОАТХ хэрэгжилтийн үр дагаврын тайлан 2025 он
<https://mta.gov.mn/files/pdf/dbku3qljhgc//67b308d2bf86de42cc0553c4.pdf>

Хуулийн дээрх зохицуулалт нь 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар шинээр нэмэгдсэн зохицуулалт бөгөөд энэ зохицуулалтын хэрэгжилтийн талаар татварын байгууллага, статистикийн байгууллагын нээлттэй мэдээлэлд энэ талаарх тоо баримт байхгүй байна.

Татварын ерөнхий хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллаж байна.

Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.6 дахь хэсэгт и-спортын үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарах агуулгыг нэмэхээр боловсруулсан хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад цаг хугацааны, хүний нөөцийн, мөнгөн зардал бий болохооргүй байна.

---o0o---